



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ
ДАРГА НАРТ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2025. 11. 14 № 01/10180
танай _____-ны № _____-т

Төсөв хүргүүлэх тухай

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын 2026 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөл боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, батлагдсан төсвийн хэрэгжилтийг зохион байгуулахад анхаарч ажиллах чиглэлийг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт №1. Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамж;

Хавсралт №2. Орон нутгийн 2026 оны суурь орлого, зарлага, санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого;

Хавсралт №3. Орон нутгийн 2026 оны хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн тооцоо.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9762003040

ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ, ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Улсын Их Хурлаас 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд тусгагдсан зарим онцлог арга хэмжээг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхэд энэхүү чиглэлийг баримтална. Монгол Улсын төсвийн нэгдмэл байдал, төсвийн сахилга батыг хангах зорилгоор орон нутгийн 2026 оны төсвийн төслийг хэлэлцэн батлахдаа дараах чиглэлийг харгалзан үзэхийг хүсье.

1. ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР

1.1. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт

1. Ирэх оны орон нутгийн төсвийн орлогыг бодит тоон мэдээлэлд суурилах, үндэслэлгүйгээр нэмэгдүүлэхгүй байх, Сангийн яамны хянасан орлогын дүнтэй уялдуулах.

2. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.1-д Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 60 хувийг улсын төсвийн орлого байхаар, мөн зүйлийн 23.6.10-т уг татварын 40 хувийг орон нутгийн төсвийн орлого байхаар тус тус заасан тул 2026 онд орон нутгийн төсөвт төвлөрүүлэх аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын хэмжээг хянасан дүнгээс нэмэгдүүлэхгүй байх.

1.2. Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг сайжруулах чиглэлээр

1. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг оны эхнээс жигд хангаж ажиллах, татварын болон бусад өр, төлбөр үүсгэхгүй байх.

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч этгээд татварын өр төлбөртэй тохиолдолд тухайн этгээдийн улсын төсвийн санхүүжилтээс тус татварын өрийг суутган тооцох арга хэмжээ авах.

3. Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй бизнес эрхлэгч, татвар төлөгчийг татварын удирдлагын нэгдсэн системд бүртгэх үйл ажиллагааг үргэлжлүүлэх, ажил гүйлгээг бүртгэлжүүлэх үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

4. Төрийн байгууллагуудын мэдээллийн уялдаа холбоог сайжруулж, төсвийн орлогын бааз суурийг өргөтгөх, татварын ногдол болон хуримтлагдсан

татварын өр төлбөрийг барагдуулах үйл ажиллагаанд анхаарч, холбогдох дэмжлэг үзүүлэн ажиллах.

5. Байгалийн нөөц ашиглах зөвшөөрөл эзэмшигчийн талаар мэдээллийг нэгтгэн бүртгэх, мэдээллийн сан байгуулах, уг сангийн мэдээллийг тогтмол баяжуулж, тус мэдээллийг харьяа татварын албатай хуваалцах.

6. Орон нутаг, Усны газар, сав газрын захиргаа, төвлөрсөн ус хангамжийн байгууллага болон татварын албаны хамтын ажиллагааг дэмжиж, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны хэмжээг үнэн зөв тогтоох, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх усны төлбөрийг бүрэн төвлөрүүлэх.

2. ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР

2.1. Зардлын эдийн засгийн ангилал

Сангийн сайдын “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай” 2025 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 112 дугаартай тушаалаар зардлын эдийн засгийн ангилал болон зардлын зориулалт-арга хэмжээг шинэчлэн баталсан бөгөөд тус шинэчилсэн ангиллыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн дагаж мөрдөхөөр заасан.

Энэ дагуу Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг дээрх шинэчилсэн ангиллын дагуу боловсруулсан бөгөөд Улсын Их Хурал Засгийн газрын өргөн мэдүүлсэн ангилалд ямар нэгэн өөрчлөлт оруулалгүйгээр баталсан болно.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, шинэчлэн баталсан ангиллын дагуу төсвийн хэрэгжилтийг зохион байгуулахаар Сангийн яамнаас бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Тиймээс аймаг, нийслэлийн төсвийг тус шинэчилсэн ангиллын дагуу боловсруулж, сум, дүүрэгтээ холбогдох чиглэлийг өгч ажиллана уу.

Зардлын эдийн засгийн ангилалд хийсэн зохицуулалтыг өмнөх ангилалтай харьцуулсныг дараах хүснэгтээс харна уу.

Код	Зохицуулалтаас өмнө	Зохицуулалтын дараа	Тайлбар
210305	-	Хөрөнгийн ашиглалтын менежмент	Шинээр нэмсэн. Энэ ангилалд төрийн өмчийн барилга байгууламжийн цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал, цахилгаан, ус болон дулааны ханган нийлүүлэлт засвар, харуул хамгаалалт, хог хаягдлын г.м төлбөртэй үйлчилгээ зэргийг багтааж төсвийн байгууллагаас гүйцэтгүүлэх тохиолдолд бүртгэнэ.

2108	Бусдаар гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	Нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	Нэршил шинэчилсэн
210801	Бусдаар гүйцэтгэсэн бусад нийтлэг үйлчилгээ	Мэргэжлийн үйлчилгээ	Нэршил болон тодорхойлолт шинэчилсэн
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	Нэгтгэсэн	210804-Тээврийн хэрэгслийн татвартай нэгтгэж нэршлийг "Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо" болгож өөрчилсөн
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний төлбөр, хураамж	Нэгтгэсэн	210807-Газрын төлбөртэй нэгтгэж нэршлийг "Нийтлэг үйлчилгээний төлбөр, хураамж" болгож өөрчилсөн
210810	-	Тохижилт үйлчилгээ	Шинээр нэмсэн. Орон нутгийн хот тохижуулалт, цэвэрлэгээ, хог тээвэрлэлт, хөшөө дурсгалын хамгаалалт зэрэг үйлчилгээг бүртгэнэ. Байгууллагын барилга байгууламжийн тохижилтын засвар нь (210604) ангилалд багтана.
210811	-	Судалгаа, хөгжүүлэлт	Шинээр нэмсэн. Шинжлэх ухаан, технологи, нийгэм, эдийн засагтай холбоотой судалгаа, зөвлөгөө, стратеги боловсруулах, үнэлгээ хийх зэрэг үйлчилгээг бүртгэнэ.
210812	-	Хувийн хэвшлийн гүйцэтгүүлэх үйлчилгээ	Шинээр нэмсэн. Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэхтэй холбоотой зарлагуудыг бүртгэнэ. Гуравдагч этгээдтэй үйлчилгээний гэрээ байгуулах, төлбөр хийх зэрэг тохиолдолд.
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	Нэршил сольсон
210903	-	Мэдээлэл сурталчилгааны зардал	Зориулалт-арга хэмжээний ангилалд өмнө нь байсан, эдийн засгийн ангилал руу шилжүүлсэн.
222002	-	ТЭЗҮ, зураг төсөв	Шинээр нэмсэн. Өмнө нь барилга байгууламжийн зардалд хамт бүртгэгдэж байсан.
222003	-	Цахим систем	Шинээр нэмсэн. Өмнө нь тоног төхөөрөмжийн зардалд хамт бүртгэгдэж байсан.

Бусдаар гүйцэтгэсэн бусад нийтлэг үйлчилгээний зардлыг судалгаа хөгжүүлэлт, хөрөнгийн ашиглалтын менежмент, харилцаа холбоо, мэдээлэл сурталчилгаа, хот тохижилт, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх үйлчилгээ болон мэргэжлийн үйлчилгээ гэсэн 8 ангилалд дахин хуваарилсан. Түүнчлэн ангилалд холбогдох зохицуулалт хийсэнтэй холбогдуулан ангиллын тайлбарт мөн зохих өөрчлөлт оруулсан.

Зардлын шинэчилсэн ангиллыг Сангийн яамны <https://mof.gov.mn/legacy/minister-order-legacy> холбоосоор орж авна уу.

2.2. Цалин хөлс, орон тоо

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд заасан төрийн албаны бүтцийг тэлэхгүй байх, төрийн албыг цомхон, давхардалгүй, чадварлаг бүтцээр ажиллуулах зорилтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын орон тоог 9 хувь бууруулах бодлогын арга хэмжээг 2025 оны төсвийн тодотголд тусгаж улсын хэмжээнд хэрэгжүүлсэн. Мөн тус арга хэмжээг 2026 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тооцож Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг боловсруулан батлуулсан. Иймд Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах байгууллагуудын чиг үүрэгт дүн шинжилгээ хийн бүтэц, зохион байгуулалтын оновчтой хувилбарыг сонгож, нэгтгэн зохион байгуулах замаар Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд аймгийн суурь зарлагад туссан төсөв, цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан үйл ажиллагаа явуулах.

2.3. Төрийн албан хаагчийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж

Төрийн албан хаагчийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 2026 онд тэтгэвэрт гарах хүсэлтээ өгсөн төрийн албан хаагчийн тоонд үндэслэн төлөвлөж, тухайн байгууллагын төсөвт тусгах бөгөөд, хуулийн дагуу өндөр насны тэтгэвэрт гарч байгаа төрийн албан хаагчид тэтгэмжийг бүрэн олгоно, хэсэгчилсэн байдлаар олгохгүй.

Шаардлагатай бол бүх шатны төсвийн захирагч нар Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт заасны дагуу төсөвтөө зохицуулалт хийх замаар төрийн албан хаагчид олгох тэтгэмжийн зардлыг бүрэн олгох зарчмыг баримтална.

Төрийн албан хаагч тэтгэвэр тогтоолгох эрх нь үүссэн ч өөрөө хүсвэл Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэгт заасны дагуу үргэлжлүүлэн ажиллах хүсэлтээ өгсөн бол тухайн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээ, туршлага, эрүүл мэндийн байдал зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр үргэлжлүүлэн ажиллуулах зарчмыг баримталж, энэ талаарх чиглэлийг төсвийн шууд захирагч нарт хүргүүлэх.

Шаардлагатай бол бүх шатны төсвийн захирагч нарын төсөвтөө зохицуулалт хийх.

2.4. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал

Орон нутгийн 2026 оны төсвийн суурь зарлагад аймгуудын байгалийн нөөц ашигласны төлбөрийн хянасан орлогоос Байгалийн нөөц ашигласны төлбөрийн

тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр тооцож байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг өмнөх оноос нэмэгдүүлэн батлуулсан.

Иймд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төсвийг батлахдаа дараах зүйлсийг анхаарна уу. Үүнд:

1/Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.4, 3.5, 3.6 дах зүйлд заасан зориулалт, арга хэмжээний зардлын тооцооллыг Сангийн яам хянаж, Засгийн газраас өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал баталсан түвшнээс бууруулахгүйгээр орон нутгийн төсөвт тусгаж, батлуулах.

2/Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын 3.7-д заасны дагуу байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хууль тогтоомжийн дагуу хуваарилагдах хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахгүй байх.

2.5. Их засварын зардлын хуваарилалт

Их засварын зардлыг төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёл, спортын байгууллагын барилга, байгууламжийн их засварын хэрэгцээ шаардлагад үндэслэн хуваарилах бөгөөд, их засварын ажлыг гүйцэтгэхдээ барилга байгууламжийн дулаан алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлтийг бий болгох, байгальд ээлтэй, нөхөн сэргээгдэх эрчим хүчний шинэ техник, технологи, хэрэглээг хянах ухаалаг тоолуурын систем нэвтрүүлэхэд түлхүү анхаарах.

2.6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20 хувьтай тэнцэх хэмжээний зардлыг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд зарцуулахаар заасны дагуу зардлыг мэдээлэл технологийн үйлчилгээний зардал эдийн засгийн ангилалд, мөн 20 хувьтай тэнцэх хэмжээний зардлыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зарцуулахаар заасны дагуу мэргэжлийн үйлчилгээний төлбөр, бараа үйлчилгээний бусад зардал, сургалт, дадлага, бэлтгэлийн зардал, мэдээлэл, сурталчилгааны зардал эдийн засгийн ангилалд тус тус тусгасан. Иймд хуулийн хэрэгжилтийг хангаж, зардлыг зориулалтын дагуу зарцуулах.

2.7. Засгийн газрын дамжуулан зээлдүүлэх зээл

Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх зээлийн хүрээнд орон нутгийн Засаг даргын Тамгын газруудын ирэх онд төлөх төлбөрийн дүн эргэн төлөлтийн хуваарийн дагуу Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд тусгагдсан тул тухайн тайлант хугацаанд хугацаа хэтэрсэн өр төлбөр хуримтлуулахгүй байх, хугацаа хэтрүүлсэн тохиолдолд Сангийн яамнаас Өрийн удирдлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.6.1 дэх заалтад заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад нь шилжүүлэх санхүүгийн дэмжлэг, ерөнхий орлогын данснаас зээлийн авлагыг суутган тооцох арга хэмжээ авах эрхтэйг тус тус анхаарах.

-o0o-

Орон нутгийн 2026 оны суурь орлого, зарлага, санхүүгийн дэмжлэг,
орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого

Сангийн Сайдын 2025 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн
10180 тоот албан бичгийн
Хавсралт-№2

	Суурь орлого	Суурь зарлага Төсвөөс санхүүжих	Үндсэн тэнцэл		Улсын төсөвт төвлөрүүлэх	Санхүүгийн дэмжлэг
			Тэнцэл	Орон нутгийн төсөвт үлдэх		
1. Архангай	27,333.4	56,717.8	-29,384.5	0.0	0.0	29,384.5
2. Баян-Өлгий	34,164.9	47,754.4	-13,589.5	0.0	0.0	13,589.5
3. Баянхонгор	39,837.5	67,894.2	-28,056.7	0.0	0.0	28,056.7
4. Булган	61,310.6	64,024.6	-2,714.0	0.0	0.0	2,714.0
5. Говь-Алтай	38,353.8	51,535.4	-13,181.7	0.0	0.0	13,181.7
6. Дорноговь	97,520.7	60,072.5	37,448.2	26,213.7	11,234.5	0.0
7. Дорнод	66,531.5	60,072.3	6,459.2	4,521.4	1,937.8	0.0
8. Дундговь	46,245.2	46,822.3	-577.0	0.0	0.0	577.0
9. Завхан	31,289.0	67,297.3	-36,008.3	0.0	0.0	36,008.3
10. Өвөрхангай	41,553.4	64,401.3	-22,847.9	0.0	0.0	22,847.9
11. Өмнөговь	1,593,752.0	264,995.7	1,328,756.4	185,497.0	1,143,259.4	0.0
12. Сүхбаатар	41,789.8	47,425.3	-5,635.5	0.0	0.0	5,635.5
13. Сэлэнгэ	100,833.2	66,372.9	34,460.2	24,122.2	10,338.1	0.0
14. Төв	85,703.9	71,882.1	13,821.8	9,675.2	4,146.5	0.0
15. Увс	33,168.7	67,995.8	-34,827.1	0.0	0.0	34,827.1
16. Ховд	55,437.0	56,315.1	-878.1	0.0	0.0	878.1
17. Хөвсгөл	43,198.4	80,006.9	-36,808.5	0.0	0.0	36,808.5
18. Хэнтий	37,367.5	62,533.1	-25,165.5	0.0	0.0	25,165.5
19. Дархан-Уул	87,310.3	51,069.0	36,241.2	25,368.8	10,872.4	0.0
20. Улаанбаатар	3,495,946.6	2,616,788.1	879,158.5	615,410.9	263,747.5	0.0
21. Орхон	218,210.0	73,917.1	144,292.9	51,742.0	92,550.9	0.0
22. Говьсүмбэр	17,820.3	22,829.1	-5,008.8	0.0	0.0	5,008.8
Нийт	6,294,677.7	4,068,722.5	2,225,955.2	942,551.3	1,538,087.0	254,683.1

/сая төгрөг/

Орон нутгийн 2026 оны хөгжлийн санд
олгох орлогын шилжүүлгийн тооцоо

Сангийн Сайдын 2025 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн
10180 тоот албан бичгийн
Хавсралт-№3

	ОНХНС-с ОНХС-д олгох орлогын шилжүүлэг				Улсын төсвөөс ОНХС-д олгох орлогын шилжүүлэг			Аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн нийт дүн
	ГТНАТ-н 30%	АМНАТ-н 10%	ЖГҮ	шилжүүлэг				
				АМХТЗ-н 100%	АМАТЗ-н 50%			
1. Архангай	292.5	8,512.2	457.9	12.1	139.6		9,414.2	
2. Баян-Өлгий	322.8	9,412.8	513.9	418.8	160.6		10,828.9	
3. Баянхонгор	410.6	16,403.9	3,399.7	290.3	1,469.9		21,974.4	
4. Булган	275.8	8,860.1	983.3	192.2	355.5		10,666.9	
5. Говь-Алтай	433.2	16,577.0	1,181.5	935.1	675.2		19,801.8	
6. Дорноговь	2,194.2	25,675.5	2,693.5	2,282.8	2,074.2		34,920.2	
7. Дорнод	2,235.1	19,850.3	4,086.2	1,043.9	591.8		27,807.2	
8. Дундговь	287.5	9,475.4	1,420.6	1,013.5	1,283.7		13,480.7	
9. Завхан	343.3	10,225.1	864.0	198.0	231.9		11,862.2	
10. Өвөрхангай	344.5	10,290.8	1,690.7	140.3	195.2		12,661.4	
11. Өмнөговь	510.5	35,137.8	3,513.4	655.6	2,741.4		42,558.7	
12. Сүхбаатар	335.9	16,440.1	3,411.8	229.9	409.9		20,827.5	
13. Сэлэнгэ	289.1	20,465.8	3,675.0	76.6	466.1		24,972.6	
14. Төв	339.6	20,207.1	926.8	175.9	1,241.9		22,891.4	
15. Увс	330.2	11,202.8	78.7	654.6	189.1		12,455.4	
16. Ховд	342.0	16,034.5	1,746.5	544.7	282.4		18,950.1	
17. Хөвсгөл	417.0	12,132.3	1,981.8		62.2		14,593.2	
18. Хэнтий	330.7	15,520.1	2,070.0	831.5	486.3		19,238.7	
19. Дархан-Уул	216.4	11,277.1	1,018.7	5.5	68.7		12,586.4	
20. Улаанбаатар	1,395.2	41,209.5			35.1		42,639.9	
21. Орхон	244.8	27,406.2	2,843.1		146.8		30,640.9	
22. Говьсүмбэр	143.5	4,506.7	309.4	28.5	130.1		5,118.2	
Нийт	12,034.2	366,822.9	38,866.5	9,729.7	13,437.7		440,891.0	

/сая төгрөг/